




Үзүүлэлтүүд:



<b>ДНБ -1.7%</b> 2016 оны III-р улирал урьдчилсан гүйцэтгэлээр	<b>ГШХО 9-р сард 41.1 сая ам.доллар</b>	<b>Төсвийн алдагдал -2320 тэрбум төгрөг</b>	<b>Инфляци -0.1%</b>	<b>Чанаргүй зээл 1046 тэрбум төгрөг</b>	<b>Валютын нөөц 1 тэрбум ам.доллар</b>
Аж үйлдвэр, барилгын салбарын нэмэгдэл өртөг 15 хувь, үйлчилгээний салбар 5 хувиар буурсан нь нөлөөлөв.	Цэвэр ГШХО 9-р сарын байдлаар 41.1 сая ам.доллар болж өмнөх сараас өссөн үзүүлэлттэй гарч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 83.5 сая ам.доллараар өсөв.	Төсвийн орлого 4494 тэрбум төгрөг, зарлага 6814 тэрбум төгрөг болж тэнцэл (2320) тэрбум төгрөгийн алдагдалтай гарав.	Өмнөх сараас 0.7 хувь буурч, оны эхнээс 0.1 хувь өсч өмнөх оны мөн үеэс 0.1 хувь буурсан байна.	Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сараас 1.1 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 22.3 хувиар нэмэгдэж 1046 тэрбум төгрөгт хүрэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээл 8.3% байна.	Монголбанкны валютын нөөц 9-р сард өмнөх сараас 4.3 хувь буюу 50 сая ам.доллараар буурч 1092 сая ам.доллар болов.

 Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш <b>2307.80 ₮</b>	 Орон сууцны үнийн индекс <b>1.013</b> Өмнөх сараас 0.19%-иар буурч, өмнөх оны мөн үеэс 7.3%-иар буурлаа.	 Монголбанкны бодлогын хүү <b>15%</b>
--	--	---

Сум, дүүргийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуулийн санал авах ажиллагааг 2016 оны 10-р сарын 19-ний лхагва гарагт Улаанбаатарын цагаар 07:00-22:00 цагийн хооронд болов. 21 аймгийн сумдын ИТХ-ын сонгуульд 6 нам, 1 эвсэл, харин дүүргийн ИТХ-ын сонгуульд 6 нам оролцов.

Экспортод гаргадаг гол түүхий эдийн үнэ, хэмжээ

Манай улсын экспортын гол бүтээгдэхүүний сар тутмын экспортын хэмжээ болон дундаж үнийг графикаар, хүснэгтээр оны эцсийн байдлаар үзүүлээ.



Сүүлийн 3 жилийн хугацаанд МУ-ын экспортын түүхий эд, өссөн дүнгээр (тэрбум ам.доллар, сая тонн)

Голлох бүтээгдэхүүн	2014 он		2015 он		2016 оны 10-р сар	
	Хэмжээ	Орлого	Хэмжээ	Орлого	Хэмжээ	Орлого
Чулуун нүүрс	19.5	0.8	14.4	0.6	18.6	6.0
Төмрийн хүдэр	6.3	0.4	6.3	0.2	4.9	2.0
Зэсийн баяжмал	1.4	2.5	1.4	2.3	1.3	1.4
<b>Нийт</b>	<b>27</b>	<b>4</b>	<b>22</b>	<b>3</b>	<b>25</b>	<b>9</b>

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2016 оны эхний гурван улиралд боловсруулах үйлдвэрлэл буурсан боловч уул уурхайн салбарын гарц, ялангуяа нүүрсний олборлолт нэмэгдсэн үзүүлэлттэй байна.


**ДНБ**

ДНБ 2016 оны 3-р улирлын байдлаар (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 11.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 193.3 тэрбум төгрөгөөр буурч эдийн засгийн өсөлт 1.7 хувиар буурав. ДНБ-ий 1.7 хувиар буурахад аж үйлдвэр, барилгын салбарын нэмэгдэл өртөг 15 хувь, үйлчилгээний салбар 5 хувиар буурсан нь нөлөөлөв.



**Төсөв**

Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 1.6% буурсан бол зарлага 24.3% өссөн нь төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2320 тэрбум төгрөгийн алдагдалтай гарахад хүргэлээ. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 1405 тэрбум төгрөгөөр өсөхөд орлого 1.7 хувиар буурч, зарлага 24.3 хувиар нэмэгдсэн нь нөлөөлжээ.




**Валютын ханш**

Аравдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 314 төгрөг буюу 15.8 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 63.8 төгрөг буюу 2.8 хувиар өсч 2307.80 төгрөгөөр сулав.



**Инфляци**

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2016 оны 10-р сард өмнөх сараас 0.7 хувь буурч, өмнөх оны мөн үеэс 0.1 хувь буурч, өмнөх оны эцсээс 0.1 хувь буурав. Үнийн дундаж түвшин өмнөх оны эцсэтэй харьцуулахад оны 10 дугаар сард өмнөх оны эцсээс 0.1 хувиар буурахад орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 3.7 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 1.8 хувь, хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 0.2 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.



\* Урьдчилсан гүйцэтгэл; Эх сурвалж УЦХ, Монголбанк

**Гадаад валютын нөөц**


Гадаад валютын улсын албан нөөц 2016 оны 9-р сарын байдлаар 1092 сая ам.доллар болов. Энэ нь өмнөх сараас 4.3 хувь буюу 50 сая ам.доллараар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 22.7 хувь буюу 320 сая ам.доллараар буурсан үзүүлэлттэй байна.



\* Эх сурвалж Монголбанк


**MSE-20 индекс**

2016 оны аравдугаар сард 51.7 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 1 сая үнэт цаас арилжсан нь өмнөх сараас гүйлгээ 3.6 хувиар, арилжсан үнэт цаас 77.5 хувиар буурчээ. ТОП-20 дундаж индекс 2016 оны аравдугаар сард 11226 нэгж болж, өмнөх сарынхаас 313, өмнөх оны мөн үеийнхээс 1899 нэгжээр буурчээ.



\* Монголын хөрөнгийн бирж

**Мөнгө** Мөнгөний нийлүүлэлт (M2) мөнгө өмнөх оны мөн үеэс 16.2 хувиар, өнгөрсөн сараас 0.4 хувиар нэмэгдэж 11.5 их наяд төгрөгт хүрэв. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өнгөрсөн оныхоос 9 хувиар, өмнөх сараас 1.3 нэмэгдэж, нийт мөнгөний 7 хувийг эзэлж байна. Өмнөх сартай харьцуулахад төгрөгийн хадгаламж өсөх хандлагатай байна.




**Хадгаламж** Нийт хадгаламж 2016 оны 10-р сард 8.2 их наяд төгрөг болж өмнөх сараас 173.4 тэрбум төгрөг буюу 2.1 хувиар өсөв. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 13.8 хувиар буюу 1005.9 тэрбум төгрөгөөр өсөв. Өмнөх сараас валютын хадгаламж 5.2 хувиар буюу 127.3 тэрбум төгрөгөөр өсч, төгрөгийн хадгаламж 0.8 хувиар буюу 46.1 тэрбум төгрөгөөр өсчээ.



**Зээл** ААН, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2016 оны 10-р сард өмнөх сарынхаас 0.1 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 4.8 хувиар нэмэгдэж 12 их наяд төгрөг болов. Чанаргүй зээлийн хэмжээ 1046 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 1.1 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 22.3 хувиар нэмэгдэв. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 8.3% байна.



**Ипотекийн зээл** 2016 оны 10-р сарын байдлаар нийт ипотекийн зээлийн үлдэгдэл өмнөх сараас 0.2 хувь (7.1 тэрбум төгрөг), өмнөх оны мөн үеэс 17.2 хувь (579.6 тэрбум төгрөг)-өөр нэмэгдэж нийт 3.9 их наяд төгрөгт хүрэв. Аравдугаар сард нийт 119 зээлдэгчид 7.1 тэрбум төгрөгийн ипотекийн зээл шинээр олгож, нийт зээлдэгчдийн тоо 88044-д хүрэв. 2016 оны есдүгээр сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдлийн 99.1 хувь нь төгрөгийн зээл, 0.9 хувь нь валютын зээл байна. Нэг зээлдэгчид ногдох тухайн сард олгосон зээлийн хэмжээ дунджаар 51.6 сая төгрөг байна.




## Гадаад худалдаа

Гадаад  
худалдаа

2016 оны эхний аравдугаар сарын байдлаар нийт барааны эргэлт 6494 сая ам.доллар, үүнээс экспорт 3726 сая ам.доллар, импорт 2768 сая ам.долларт хүрч гадаад худалдааны тэнцэл 957 сая ам.долларын ашигтай гарлаа. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 8.4 хувь, экспортын хэмжээ 5.1 хувиар, импортын хэмжээ 12.4 хувиар тус тус буурчээ. Импорт өмнөх оны мөн үеэс 395.3 (12.5%) сая ам.доллараар буурахад эрдэс бүтээгдэхүүний импорт 224.8 сая ам.доллар, үүнээс дизелийн түлш 127.9 сая ам.доллар, автобензин 80.3 сая ам.доллараар буурахад голлон нөлөөлжээ.

## Гадаад худалдаа




\* Эх сурвалж УЦХ, Монголбанк

Гадаадын  
шууд  
хөрөнгө  
оруулалт

Гадаадын шууд хөрөнгө оруулалт 2016 оны 9-р сард 41.1 сая ам.долларын эерэг үр дүнтэй гарлаа. Харин өмнөх оны мөн үеэс 83.5 сая ам.доллараар өсөв. Өмнөх сартай харьцуулахад Монгол Улсад 29.4 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгджээ.

## Гадаадын шууд хөрөнгө оруулалт




\* Эх сурвалж Монголбанк

## Монгол Улсын гадаад өр

### Гадаад өр

2016 оны хоёрдугаар улиралд Засгийн газрын нийт гадаад өр 4 тэрбум ам.доллар, Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 23.4 тэрбум ам.доллар болсон байна. Энэ нь өмнөх улирлаас ЗГ-ын өр 17 хувь (670 сая ам.доллар), Улсын нийт гадаад өр 4 хувь (850 сая ам.доллар)-иар тус тус буурсан байна. Тайлант улиралд нийт Улсын гадаад өрийн 20 хувийг засгийн газрын өр, 7 хувийг Төв банкны өр, 9 хувийг хадгаламжийн байгууллагуудын өр, 34 хувийг бусад салбаруудын өр, 29 хувийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна. Төв банкны нийт өрийн 96 хувийг богино хугацаат, 4 хувийг урт хугацаат өглөг эзэлж байна.



\* Эх сурвалж Монголбанк

### Сарын онцлох үйл явдал

#### 10.13

НҮБ-ын Дэлхийн Аялал жуулчлалын байгууллага, Монгол Улсын БОАЖЯ, Дэлхийн хотуудын шинжлэх ухааны хөгжлийн холбоо олон улсын байгууллага, нийслэлийн ЗДТГ хамтран "Нүүдлийн аялал жуулчлал ба хотуудын тогтвортой хөгжил" сэдэвт Торгоны замын олон улсын бага хурал энэ сарын 13-15-нд болж өндөрлөв. Нүүдлийн соёл иргэншилтэй манай улсад асар их хөрөнгө оруулалт татах боломж байгааг тус хуралд хүрэлцэн ирсэн хүндэт зочид онцолж байна. Энэ хуралд НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын ерөнхий нарийн бичгийн дарга Талейб Рифай тэргүүтэй дэлхийн торгоны замын аялал жуулчлалын хөтөлбөрийн гишүүн 33 орны 150 гаруй төлөөлөгч, мөн манай улсаас 350 гаруй төлөөлөл оролцов.

#### 10.20

“Оюу Толгой”-ийн хүдрийн олборлолт өнгөрсөн улиралд тус компанийн түүхэн дэх дээд хэмжээ болох 25.7 сая тоннд хүрч нэмэгдсэн ч хүдэр дэх агуулга багассанаас үүдэн зэс, алтны үйлдвэрлэл буурсан үзүүлэлттэй байна. Ийнхүү үйлдвэрлэл буурсан ч оны эцэст зорилтот түвшинд хүрнэ гэдгийг албаныхан хэлж буй юм. Тус компани оны эцэст 185 мянган тонн зэс, 7.7 орчим тонн алт үйлдвэрлэх төлөвлөгөөтэй байгаа бөгөөд оны эхний гурван улирлын дүнгээр зорилтынхоо 80 гаруй хувийг гүйцэтгэжээ.